



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/147

Улаанбаатар хот

"Захирамжлалын баримт бичиг гаргах
ажиллагааны журам"-д нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь хэсэг, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/465 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын 2021 оны А/43 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан "Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт захирамжлалын баримт бичгийн төслийг хянаж, санал өгөх албан тушаалтнуудын жагсаалтад "Дүүргийн менежер" гэж нэмсүгэй.

2.Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагаанд санал өгөх "Хяналтын дагалдах хуудас"-ны загварыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

3."Хяналтын дагалдах хуудас"-ны загвар шинэчлэн батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2021 оны "Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам" шинэчлэн батлах тухай А/43 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л. Санжийжамц)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 09 сарын 11-ны өдрийн 11/11 дугаар
захирамжийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖИЙН ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

..... оны дугаар сарын Дугаар

Захирамжийн төслийн нэр:
.....
.....

Боловсруулсан байгууллага ажилтны албан тушаал, нэр:
.....
.....

Хянасан:
.....
.....

№	Санал өгөх газар, хэлтэс	Сонирхлын зөрчилтэй эсэх	Санал	Гарын үсэг	Он, сар, өдөр	
					Хүлээн авсан	Хүлээлгэн өгсөн
1	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч					
2	Дүүргийн менежер					
3	Засаг даргын Тамгын газрын дарга					
4	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга					
5	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга					
6	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга					
7	Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга					

Дүүргийн Удирдлагын зөвлөлийн хуралд оруулах, захирамж гаргах саналыг дэмжиж зөвшөөрсөн:

№	Санал өгөх газар, хэлтэс	Сонирхлын зөрчилтэй эсэх	Санал	Гарын үсэг
1	Засаг дарга			
2	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч			
3	Дүүргийн менежер			
4	Засаг даргын Тамгын газрын дарга			
5	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга			
6	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга			
7	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга			
8	Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга			
9	Дотоод аудитын албаны дарга			
10	Газар зохион байгуулалтын албаны дарга			